

ЗӨВ САНХҮҮЖИЛТ

2021 ОНЫ

3 ДУГААР УЛИРЛЫН  
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

**InvesCore**  
САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА

**АГУУЛГА**

Гол амжилтууд	03
Бондын хөтөлбөр	04
Хувьцааны арилжаа	05
Борлуулалтын суваг	06
Зээлийн бүтээгдэхүүн	07
Санхүүгийн байдлын тайлан	09
Орлого үр дүнгийн тайлан	10
Зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд (тусдаа)	11
Жижиг дунд бизнес эрхлэгчдийг дэмжих хөтөлбөр	12
Олон улсын стандарт	13




## ГОЛ АМЖИЛТУУД

- ✓ Олон улсын “MicroFinanza Rating” SRL байгууллагаас Монгол улсдаа хамгийн өндөр “A- High” үнэлгээ авлаа.
- ✓ Хувийн хэвшлийн түүхэн дэх хамгийн том бөгөөд анхны нээлттэй 20 тэрбум төгрөгийн бондын хөтөлбөрийг хэрэгжүүлж, 100% амжилттай хөрөнгө татан төвлөрүүллээ.
- ✓ Чанарын удирдлагын (ISO 9001) болон мэдээллийн аюулгүй байдлын (ISO 27001) стандартыг нэвтрүүлж эхэлсэн.
- ✓ Нэгж хувьцаанд 17 төгрөг буюу нийт 1.2 тэрбум төгрөгийн ногдол ашгийг хувьцаа эзэмшигч нартаа тараасан.
- ✓ “Рио Тинто Монгол” ХХК-тай хамтран жижиг дунд бизнес эрхлэгчдэд зориулсан бага хүүтэй зээлийн бүтээгдэхүүн гаргалаа.
- ✓ “Инвескор ББСБ” ХК нь Тогтвортой Санхүүжилтийн Холбоо (ТоС)-нд үндсэн гишүүнээр элссэн.
- ✓ “Инвескор ББСБ” ХК нь Монголын Хөрөнгийн Бирж дээрх үнэт цаасны бүртгэлийн 1 дүгээр ангилалд дэвшин орлоо.
- ✓ “Инвескор Санхүүгийн Групп” нь Токио-2020 зуны олимпын наадмын шууд дамжуулалтын “Алтан Ивээн Тэтгэгч”-ээр ажиллалаа.

## БОНДЫН ХӨТӨЛБӨР

Хөтөлбөрийн нийт үнийн дүн	20.0 тэрбум төгрөг
Нэгж бондын нэрлэсэн үнэ	100,000 төгрөг
Нийт тоо, ширхэг	200,000 ширхэг хүртэлх
Анхдагч зах зээлийн хуваарь	6, 8, 9 сар
Бондын хугацаа	24 сар
Бондын хүү (жилийн)	13%
Хүү төлөх давтамж	Хагас жил тутам
Үндсэн төлбөр төлөх давтамж	Хугацааны эцэст
Бондын зарцуулалт	Бизнесийн зээл 11 тэрбум /55%/, хэрэглээний зээл 9 тэрбум /45%/
Бондын барьцаа	"Эс Ай Би Жэй Капитал" ХХК-ийн эзэмшиж буй Үнэт цаас гаргагчийн 12,000,000 ширхэг энгийн хувьцаа
Бондын эргэн төлөлт	Үнэт цаас гаргагчийн хүү, шимтгэлийн орлого болон харилцагчдад олгосон зээлийн үндсэн төлбөр

## ТАТВАРЫН ДАРААХ ЖИЛИЙН ХҮҮ



2 жилийн хугацаатай банкны хадгаламжуудыг  
Инвескор бондтой харьцуулсан харьцуулалт

(2021.09.30 байдлаар)

### ✓ Хөтөлбөрийн биелэлт

- Анхдагч зах зээлийн захиалга 130%-иар давж биелсэн.

## ХУВЬЦААНЫ АРИЛЖАА



## 2021 оны 3 дугаар улирлын байдлаар:

- ✓ Зах зээлийн үнэлгээ: **242.6 тэрбум төгрөг**
- ✓ Нийт арилжаалагдсан ширхэг: **1,548,340**
- ✓ Нийт арилжаалагдсан дүн: **4.3 тэрбум төгрөг**
- ✓ Өдрийн дундаж дүн: **23.2 сая төгрөг**
- ✓ “Инвескор ББСБ” ХК-ийн хувьцааны ханш өмнөх оны мөн үеэс **21 хувиар** өсч, **3382 төгрөгт** хүрсэн байна.
- ✓ IPO хийсэн цагаас хойш хувьцааны ханш нийт **106 хувиар** өссөн амжилттай байна.

## БОРЛУУЛАЛТЫН СУВАГ

- ✓ 2021 оны эхний хагас жилд бид шинээр 4 салбар байгуулсан бөгөөд Улаанбаатар хотод 15 салбар, Эрдэнэт хотод 1 салбар, Цахим хэлбэрээр 1 нийт 17 салбартайгаар үйл ажиллагаагаа явуулж байна.
- ✓ Шинээр нээгдсэн салбарууд:
  - Авто Экспо (Уран Ган авто худалдааны төвийн хажууд)
  - Их Монгол
  - Яармаг
  - Дижитал салбар
- ✓ 2021 оны 4 дүгээр улиралд шинээр 2 салбар нээх төлөвлөгөөтэй ажиллаж байна.
- ✓ Инвескор Аллианс хөтөлбөр нь орон нутгийн ББСБ-уудыг чадавхжуулах, үйл ажиллагааг нь өргөжүүлэх зорилготой ба одоогийн байдлаар Өмнөговь, Дорнод болон Өвөрхангай аймгийн ББСБ нар уг хөтөлбөрийн гишүүнээр элсээд байна.
- ✓ Инвескор ББСБ ХК нь орон нутгийн ББСБ-уудыг чадавхижуулж, шаардлагатай эх үүсвэрийг хангаж ажилласнаар орон нутагт үйл ажиллагаа эрхэлдэг жижиг дунд бизнес эрхлэгчдийн үйл ажиллагааг дэмжиж, санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлнэ.
- ✓ 2021 оны 4 дүгээр улиралд шинээр 2 аймгийн ББСБ-уудыг элсүүлж, нийт 5 гишүүнтэй болохоор ажиллаж байна.






## 3 ДУГААР УЛИРЛЫН ТАЙЛАН 2021


## ЗЭЭЛИЙН БҮТЭЭГДЭХҮҮН

Зээлийн багц (сая төгрөг)



- ✓ 2021.09.30 байдлаар нийт зээлийн багц өмнөх оны мөн үеэс 76 хувиар өсч, 149.5 тэрбум төгрөгт хүрсэн байна.
- ✓ Нэг зээлдэгчид ноогдох хэмжээ 0.7 сая төгрөг байгаа нь зээлийн эрсдэл буурах гол хүчин зүйл болж байна.


Зээлийн эргэн төлөлт ба олголт (сая төгрөг)



- ✓ Өмнөх оны мөн үетэй харьцуулахад зээл эргэн төлөлтийн дүн 141 хувиар, зээл олголтын дүн 140 хувиар тус тус өсчээ.
- ✓ Цар тахлын үед бид сегментэд суурилсан нээлттэй борлуулалтын тактикийг баримталж ажилласан.


## ЗЭЭЛИЙН БҮТЭЭГДЭХҮҮН

Зээлийн багц, бүтээгдэхүүнээр



- ✓ Бид хэрэглээний зээлийн процессыг автоматжуулж, илүү бизнесийн зээл рүү төвлөрөн ажиллаж байгаа бөгөөд ногоон зээл болон ЖДҮ-ийн санхүүжилтийг дэмжих хөнгөлөлттэй нөхцөл бүхий бүтээгдэхүүнүүдийг нэвтрүүлж байна.
- ✓ Бизнесийн харилцагч нарт бид зөвхөн санхүүжилт олгохоос гадна сургалт, зөвлөх үйлчилгээг үнэ төлбөргүй үзүүлж харилцагчаа дэмжиж ажилласаар ирсэн.

Зээлийн багцын чанар




- ✓ “Инвескор ББСБ” ХК-ийн зээлийн багцад эзлэх хугацаа хэтэрсэн зээлийн хувь, чанаргүй зээлийн эзлэх хувь санхүүгийн секторын хэмжээнд хамгийн бага түвшинд байна.
- ✓ Гол шалтгаан нь зээлийн судалгаа, олголтын үйл ажиллагааг бүрэн автоматжуулсан, мөн зээлийн шийдвэр гаргалтад нөлөөлөх хүний хүчин зүйлийг зохистой түвшинд хязгаарлаж, олон улсын түвшний скоринг систем ашигладагт оршино.




**“ИНВЕСКОР ББСБ” ХК  
НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ХУРААНГУЙ ТАЙЛАН**

САЯ ₮	2020.09.30	2021.09.30
Мөнгөн хөрөнгө	22,408	10,702
Хөрөнгө оруулалт	3,617	1,205
Харилцагчдад олгосон зээл - цэвэр	83,036	146,303
Зээлийн багц	84,891	149,543
зЭС	(1,856)	(3,239)
Хуримтлагдсан хүүгийн авлага	4,241	5,112
Авлага	4452	4089
ӨБҮХХ	-	67
Бусад актив	1,499	2,660
Үндсэн ба биет бус хөрөнгө	7,429	9,222
<b>НИЙТ ХӨРӨНГӨ</b>	<b>126,683</b>	<b>179,360</b>
Итгэлцлийн өглөг	39,570	44,845
Банк, санхүүгийн байгууллагаас авсан зээл	16,645	21,113
Бонд	6,611	24,573
Хуримтлагдсан хүүгийн өглөг	6,539	5,196
Бусад өглөг	6,054	19,951
<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>75,419</b>	<b>115,678</b>
Хувьцаат капитал	16,282	16,282
Нэмж төлөгдсөн капитал	15,378	15,378
Хуримтлагдсан ашиг	19,605	32,022
<b>НИЙТ ӨӨРИЙН ХӨРӨНГӨ</b>	<b>51,265</b>	<b>63,682</b>

Нийт хөрөнгө (сая төгрөг)




Өөрийн хөрөнгө (сая төгрөг)




## ОРЛОГО ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

САЯ ₮	2020.09.30	2021.09.30
Хүүгийн орлого	18,301	25,958
Хүүгийн зардал	4,035	8,593
Бусад хүүгийн зардал	2,861	3,129
Итгэлцлийн хүүгийн зардал	1,173	5,464
Цэвэр хүүгийн орлого	14,267	17,365
Шимтгэл хураамжийн орлого	4,282	6,029
Үйл ажиллагааны зардал	4,928	7,917
Хүний нөөцийн зардал	2,211	3,867
Үйл ажиллагааны бусад зардал	2,717	4,050
Гадаад валютын ханшийн олз (гарз)	(194)	(111)
Зээлийн үнэ цэнэ бууралтын өмнөх ашиг	13,427	15,366
Эрсдлийн сангийн зардал	2,470	1,884
Үйл ажиллагааны бус орлого (зардал)	-	686
Татвар төлөхийн өмнөх ашиг	10,957	14,168
Татварын зардал	914	2,457
Цэвэр ашиг	10,043	11,712

Хүү, шимтгэлийн орлого (сая төгрөг)



Цэвэр ашиг (сая төгрөг)



## ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД (тусдаа)

Шалгуур үзүүлэлт	Байх ёстой	2020.09.30	2021.09.30
1-р зэрэглэлийн өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн нийт активын харьцаа	10%-иас доошгүй	42.3%	30.6%
Өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн нийт активын харьцаа	20%-иас доошгүй	42.3%	30.6%
1-р зэрэглэлийн өөрийн хөрөнгө, нийт активын харьцаа	10%-иас доошгүй	39.9%	33.6%
Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа	8%-иас дээш	37.7%	9.1%
Нэг зээлдэгч, түүний холбогдох этгээдэд олгосон зээл / Өөрийн хөрөнгө	30%-иас хэтрэхгүй	9.9%	13.8%
ББСБ-аас гаргасан төлбөрийн баталгааны зохистой харьцаа	70%-иас хэтрэхгүй	0.0%	0.0%
Нийт холбогдох этгээдэд олгосон зээл / Өөрийн хөрөнгө	25%-иас хэтрэхгүй	0.7%	0.5%
Нэг холбогдох этгээдэд олгосон зээл / Өөрийн хөрөнгө	10%-иас хэтрэхгүй	0.1%	0.0%
Үнэт цаасны эзэмшил / өөрийн хөрөнгө	50%-иас хэтрэхгүй	12.3%	10.1%
Гадаад актив, пассивын зөрүү өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	+/-40%-иас хэтрэхгүй	12.8%	33.7%
Итгэлцлийн өглөг өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	80%-иас хэтрэхгүй	79.4%	75.3%
Өрийн бичгийн зохистой харьцаа	50%-иас хэтрэхгүй	13.3%	41.3%
Үндсэн хөрөнгийн зохистой харьцаа	15%-иас хэтрэхгүй	4.0%	3.5%

## ЖИЖИГ ДУНД БИЗНЕС ЭРХЛЭГЧДИЙГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨР

Ковид-19 цар тахлын үед Монгол улсын эдийн засгийг сэргээхэд дэмжлэг үзүүлэх, бичил, жижиг, дунд бизнес эрхлэгчдийг дэмжих хөнгөлөлттэй зээлийн хөтөлбөрийг "Инвескор ББСБ" ХК нь "Рио Тинто Монгол" ХХК-тай хамтран хэрэгжүүлж байна.

### ХАМТАРСАН ХӨТӨЛБӨРИЙН НӨХЦӨЛ



#### Зээлийн барьцаа

60% хүртэл үл хөдлөх болон хөдлөх хөрөнгө  
40% хүртэл эргэлтийн хөрөнгө

#### Үндсэн төлбөрөөс чөлөөлөх хугацаа

Үндсэн зээл, хүүгийн төлбөр тогтмол

#### Зээлдэгчид тавигдах шаардлага

- Үйлдвэрлэл үйлчилгээний бизнес эрхэлдэг байх;
- Байгаль орчинд ээлтэй бүтээгдэхүүн, үйлчилгээ эрхэлдэг байх;
- 6 сар ба түүнээс дээш хугацаагаар идэвхтэй үйл ажиллагаа явуулсан байх



## ОЛОН УЛСЫН СТАНДАРТ

### “ИНВЕСКОР ББСБ” ХК ISO 9001 & 27001 ОЛОН УЛСЫН СТАНДАРТЫГ НЭВТРҮҮЛЭХ АЖЛЫГ ЭХЛҮҮЛЛЭЭ.

“ИНВЕСКОР ББСБ” ХК нь үйл ажиллагаа өргөжин тэлэхийн хэрээр дэлхийн түвшинд хүлээн зөвшөөрөгдсөн, олон улсын стандартын шаардлагад бүрэн нийцсэн үйл ажиллагаа явуулахыг зорин ажиллаж байна.


Бид үйл ажиллагаандаа Чанарын удирдлагын тогтолцооны ISO 9001 болон Мэдээллийн аюулгүй байдлын удирдлагын тогтолцооны 27001 олон улсын стандартуудыг нэвтрүүлэхээр болсныг эрхэм харилцагч та бүхэндээ дуулгахад таатай байна.



### “ИНВЕСКОР ББСБ” ХК НЬ MICROFINANZA RATING БАЙГУУЛЛАГААС “A- HIGH” ҮНЭЛГЭЭ АВЛАА

“Мөрөөдлөө санхүүжүүл” уриатай “Инвескор ББСБ” ХК нь олон улсын “MicroFinanza Rating” SRL байгууллагаас Монгол улсдаа хамгийн өндөр буюу “α- High” үнэлгээ авлаа. Уг үнэлгээг тогтоосон гол хүчин зүйлүүд нь “Инвескор ББСБ” ХК-ийн компанийн засаглал, стратеги, зээлийн багцын чанар, үйл ажиллагаа, систем, санхүүгийн төлөв байдал зэрэг юм.

Ингэснээр “Инвескор ББСБ” ХК-ийн гадаад зах зээлээс эх үүсвэр татах боловч хөрөнгө оруулагч нартай түншлэлээ идэвхжүүлэх үйл ажиллагаанд давуу тал үүсэх юм. “MicroFinanza Rating” SRL нь банк, санхүүгийн байгууллагуудын зээлжих зэрэглэлийг тогтоодог олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн агентлаг бөгөөд 2000 оноос хойш дэлхийн 100 гаруй орны, 2000 гаруй санхүүгийн байгууллагуудад үнэлгээ хийжээ.





**InvesCore**  
САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА